

Хавхлаганы байрлалын горим алдагдвал ноцтой осол учирч болзошгүй.

2021 оны 5-р сар



Зураг 1

Хадгалах танкны гал




Зураг 2

Шугамын хаалт



Зураг 3

Ослын дараах
Шугамын хаалт



Зураг 4

Шугам
хоолойн схем

2009 оны 10-р сард хадгалах танкнаас 260,000 гаруй галлон (984 м³) шатахуун алдагдаж, томоохон хэмжээний дэлбэрэлт үүссэний улмаас хоёр операторыг оролцуулан 11 хүн амиа алдсан байна (Зураг 1). Албан ёсны мэдээллээр оператор шугамын хаалтыг ашиглан танкийг дүүргэх горимоос юүлэх горимд шилжүүлэхдээ хавхлаганы үйл ажиллагааны дараалалд алдаа гаргажээ. (Зураг 2 ба 3).

Нэг оператор А болон В хавхлагыг хаасны дараа С шугамын хаалтыг нээлттэй горимоос хаалттай горимд шилжүүлжээ. Үүний дараа чухам юу болсон талаарх дүгнэлтийг албан ёсны мэдээлэлд дурдаагүй ба учир нь хоёр оператор ослоор амиа алдсан. Хэсэг хугацааны дараа өөр нэг оператор F шугамын хаалтыг хаалттай горимоос нээлттэй горимд шилжүүлсэн бөгөөд шугамын хаалтны дээд хэсгийн нээлхийгээр шатахуун хурдтай гоожиж эхэлсэн аж. Ослын дараа E гар хавхлага болон D моторт хавхлага (MOV) хоёулаа нээлттэй горимд байгааг тогтоожээ. (Зураг 4)

11 хүн амиа алдаж, 11 өдрийн турш түймэр шатсан ба тухайн терминал бүрэн сүйрчээ.

Та мэдэх үү?

- Гар хавхлага нь ойр ойрхон ашиглагдахгүй байх магадлалтай ба суулт нь элэгдэж хуучрах, нягтруулгын гадаргууд бохирдол тээглэх, зэврэлт үүсэх зэрэг олон шалтгааны улмаас бүрэн нягтрахгүй байж болзошгүй.
- Гар хавхлагануудад зориулсан олон төрлийн тохиргоо байдаг. Зөв байрлал нь тодорхой бус бол лавлаж асуу.
- Ноцтой эрсдэлтэйд тооцогддог гар хавхлагануудыг ерөнхийдөө тухайн байрлалд нь зориулалтын цоож эсвэл пайз зүүж лацаддаг. Тэдгээрийг ашиглахад онцгой анхаарал болгоомж шаардлагатай.
- Шугамын хаалт аюулгүй хаагддаг боловч ихэвчлэн байрлалыг нь өөрчилсөн тохиолдолд бага хэмжээний гоожилт үүсэх, улмаар бүрэн алдагдах боломжтой. Шугамын хаалт шилжүүлэх ажилд шугам задрах нөхцөл байдалтай адил хандаж, ажлын зөвшөөрөл ашигла.
- Зарим хавхлага үйл ажиллагааны зохих дараалалтай байдаг ба үүнийг ажлын процедурт тэмдэглэх хэрэгтэй.

Та юу хийж болох вэ?

- Хавхлаганы байрлал өөрчлөх ажлыг зөв гүйцэтгэхийн тулд журам, шугам хоолойн зураг, схемийг хар. Хэрэв журам эсвэл зураг нь ажлын талбай дээр зөрж байвал ажлыг үргэлжлүүлэхийн өмнө асууж тодруул. Журам эсвэл зураг алдаатай байж болно.
- Шугамын хаалтыг ашиглах хэрэгтэй бол байрлалыг нь өөрчлөхийн өмнө зохих тусгаарлалтыг хийж, ажлыг эхлүүлэхэд бүрэн аюулгүй эсэхийг баталгаажуул.
- Хавхлагыг тухайн байрлалд нь зориулалтын түгжээ зүүж лацадсан бол энэ талаар процедурт тэмдэглэсэн байдаг. Хэрэв тодорхой бус бол ажлыг эхлүүлэхийн өмнө хавхлага зөв эсэхийг баталгаажуул.
- Аливаа нэг хавхлагыг ашиглахын өмнө бүх зайлуулах хоолой, дээжний крантыг хаах нь чухал. Хэрэв ажлын процедурт хавхлаганы байрлалыг өөрчлөх тодорхой дараалал тусгагдсан бол түүнийг мөрд.
- Хавхлаганы ажилд 2 ба түүнээс дээш баг оролцдог бол ажил үргэлжлүүлэхийн өмнө хавхлаганы бүх байрлал зөв эсэхийг баталгаажуул.

Гар хавхлагыг ашиглахын өмнө нөхцөл байдлыг хянахад тусгайлан цаг зарцуул.